НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 07 өдөр Дугаар А/60 Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн оны "Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх Биеийн тамир, спортын хамтлагуудын үйл ажиллагааны тайлан үр дүнг үндэслэн Нийслэл, дүүргийн 2023 оны "Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг"-уудыг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Нийслэл, дүүргийн 2023 оны "Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 4,870,000 (Дөрвөн сая найман зуун далан мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй

4.Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

D:\orshih\Buyan-Orshikh\Tushaal\A tushaal\2023.12 sar hamtlag.docx

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2023 оны ..... дугаар сарын .....-ны
өдрийн ...../..... дугаар тушаалын хавсралт

Нийслэл, дүүргийн 2023 оны
“Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг”
шалгаруулах арга хэмжээний төсөв

№	Зардлын нэр		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.	Тамирчдын шагнал	1-р байр	2	500,000	1,000,000
		2-р байр	2	400,000	800,000
		3-р байр	2	300,000	600,000
2.	Карказ, үзель, чимэглэл		-	-	1,880,000
3.	Хулдаасан хэвлэл		40м2	12,500	500,000
4.	Цом		6	60,000	360,000
5.	Өргөмжлөл		6	60,000	360,000
ДҮН					4,870,000